



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Цогт-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2026/129/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Даланзадгад хот

2026 он

Өмнөговь дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр

Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Хонгорзул

Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор: Ж.Болормаа

Утас: 70533552 Цахим хаяг: bolormaaja@audit.gov.mn

Аудитор: Э.Жаргал

Утас: 70533552 Цахим хаяг: jargale@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.02.23 № 59
танай _____-ны № _____-т

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЦОГТ-ОВОО
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Д.ЗУЛЦЭЦЭГ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өмнөговь аймгийн Цогт-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайланд тусгасан оны эхний 1,291.9 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй, 52,517.5 мянган төгрөгийн тээвэр шатахууны зарцуулалтын тайлан гаргасан эсэх нь баримтаар нотлогдохгүй, зүүн бүсийн төрийн албан хаагчдын спорт арга хэмжээг зохион байгуулан уралдаан тэмцээний зардлаас 2,850.0 мянган төгрөгийн медаль худалдан авч төсвийг үр ашиггүй зарцуулсан зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 20 дугаар зүйлийн 20.2.3, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.1.8 дахь заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, ангилал, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар мал нядалгааны цэгийг байгуулан 546,476.8 мянган төгрөгийн барилга байгууламж, тоног төхөөрөмж үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэлд тусгасан байна.

4626350056

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Өмнөговь аймгийн хэмжээнд хэрэгжүүлж буй "Нутгийн дэм" хөтөлбөрт байгууллагын ажилтан албан хаагчдыг хамруулж 73,014.1 мянган төгрөг, орон нутгийн нэмэгдэл 249,374.5 мянган төгрөгийг олгосон байна.

Бусад асуудал хэсэг

Тайлант онд Говийн оюу хөгжлийг дэмжих сангийн хөрөнгө оруулалтаар ахмадын өргөөний барилга, тоног төхөөрөмж хүлээн авч ашиглалтад оруулсан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Балансын зүйл	Тодруулга	Өмнөх он	Тайлант он
МӨНГӨН ХӨРӨНГӨ	4	-	-
Кассад байгаа бэлэн мөнгө		-	-
Банканд байгаа бэлэн мөнгө		-	-
Замд яваа мөнгөн хөрөнгө		-	-
АВЛАГА	5	19,021,988.00	156,241,370.00
Ажиллагчидтай холбогдсон авлага		1,291,988.00	-
Бусад авлага		17,730,000.00	156,241,370.00
Байгууллагаас авах авлага		-	156,241,370.00
Хувь хүмүүсээс авах авлага		17,730,000.00	-
УРЬДЧИЛГАА		-	-
БАРАА МАТЕРИАЛ	6	567,661,126.82	588,222,390.82
Хангамжийн материал		539,344,626.82	547,819,626.82
Бусад хангамжийн материал		539,344,626.82	547,819,626.82
Мал амьтад		28,316,500.00	40,402,764.00
НӨӨЦИЙН БАРАА		31,772,500.00	9,790,300.00
Тэжээлийн нөөц		31,772,500.00	9,790,300.00
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		618,455,614.82	754,254,060.82
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7	11,402,449,188.55	13,208,107,175.95
Биет хөрөнгө		11,150,111,938.89	12,955,901,825.93
Барилга, байгууламж, орон сууц		10,242,425,248.73	7,495,323,520.13
Хуримтлагдсан элэгдэл		(2,331,437,420.98)	(544,584,097.00)
Авто-тээврийн хэрэгсэл		770,217,800.00	573,346,710.00
Хуримтлагдсан элэгдэл		(215,502,455.38)	(191,072,908.74)
Машин тоног төхөөрөмж (компьютер)		337,980,557.93	363,003,117.93
Хуримтлагдсан элэгдэл		(127,579,199.49)	(179,792,032.60)
Тавилга, аж ахуйн эд хогшил		172,826,647.00	205,681,647.00
Хуримтлагдсан элэгдэл		(52,897,868.90)	(71,263,021.20)
Бусад үндсэн хөрөнгө		3,221,883,559.44	8,808,895,674.04
Хуримтлагдсан элэгдэл		(867,804,929.46)	(3,503,636,783.63)
Биет бус хөрөнгө		252,337,249.66	252,205,350.02
Программ хангамж		5,184,500.00	5,184,500.00
Хуримтлагдсан элэгдэл		(4,822,850.34)	(4,954,749.98)
Бусад биет бус хөрөнгө		251,975,600.00	251,975,600.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		11,402,449,188.55	13,208,107,175.95
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		12,020,904,803.37	13,962,361,236.77
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9	63,590,512.03	192,135,383.50
Өглөг		63,590,512.03	192,135,383.50
Ажилчидтай холбогдсон өглөг		1,354,893.22	690,246.95
Бараа үйлчилгээний зардлын өглөг		-	8,995,193.55
Бусад өглөг		62,235,618.81	182,449,943.00
Байгууллагад төлөх өглөг		60,305,152.00	170,847,863.00
Хувь хүмүүст төлөх өглөг		1,930,466.81	11,602,080.00

НИЙТ ӨР ТӨЛБӨР		63,590,512.03	192,135,383.50
Засгийн газрын хувь оролцоо		11,957,314,291.34	13,770,225,853.27
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		574,817,234.31	574,817,234.31
Хуримтлагдсан үр дүн		11,348,209,758.83	13,161,121,320.76
Өмнөх үеийн үр дүн		11,348,209,758.83	11,348,209,758.83
Тайлант үеийн үр дүн		-	1,812,911,561.93
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		34,287,298.20	34,287,298.20
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		11,957,314,291.34	13,770,225,853.27
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		12,020,904,803.37	13,962,361,236.77

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Тодруулга	Өмнөх он	Тайлант он
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		3,506,520,673.00	4,534,367,800.00
Нэмэлт санхүүжилтийн орлого		1,994,526,873.00	2,356,530,416.00
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,982,669,284.00	2,351,763,789.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		10,107,589.00	2,166,627.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		1,750,000.00	2,600,000.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих		1,511,993,800.00	2,177,837,384.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		1,511,993,800.00	2,177,837,384.00
Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		-	-
ТАТВАРЫН БУС ОРЛОГО		4,325,761,657.93	2,377,675,330.00
Нийтлэг татварын бус орлого		4,325,761,657.93	2,377,675,330.00
Төсөв байгууллагын өөрийн орлого		28,345,450.00	-
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		28,345,450.00	-
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		4,122,491,207.93	2,351,314,066.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		174,925,000.00	26,361,264.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2	7,832,282,330.93	6,912,043,130.00
УРСГАЛ ЗАРДАЛ		3,381,702,378.33	3,126,029,516.37
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		3,119,678,053.25	2,663,965,428.15
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		684,501,744.91	766,853,275.25
Үндсэн цалин		331,606,460.49	310,192,427.00
Нэмэгдэл		261,781,443.95	325,497,536.00
Унаа хоолны хөнгөлөлт		21,366,457.00	38,336,364.00
Урамшуулал		64,914,781.21	88,734,751.25
Гэрээт ажлын хөлс		4,832,602.26	4,092,197.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		85,827,030.00	97,460,561.70
Тэтгэврийн даатгал		57,148,586.00	64,742,942.70
Тэтгэмжийн даатгал		6,875,362.00	8,177,180.00
ҮОМШӨ-ний даатгал		4,026,179.00	4,088,588.75
Ажилгүйдлийн даатгал		4,026,179.00	4,088,588.75
Эрүүл мэндийн даатгал		13,750,724.00	16,363,261.50
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		86,858,740.83	101,651,575.30
Гэрэл, цахилгаан		5,523,921.88	10,179,281.75
Түлш, халаалт		81,334,818.95	91,472,293.55
Хангамж, бараа материалын зардал		78,737,003.00	262,952,880.00
Бичиг хэрэг		8,008,550.00	5,299,800.00
Тээвэр, шатахуун		53,450,253.00	52,677,580.00

Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		3,385,400.00	4,583,800.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэргэгчдийн устгал, ариутгал		9,000,000.00	197,822,400.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		4,892,800.00	2,569,300.00
Норматив зардал			877,300.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл			877,300.00
Эд хогшил, урсгал засварын зардал		32,730,200.00	43,620,378.00
Урсгал засвар		32,730,200.00	43,620,378.00
Томилолт, зочны зардал		17,830,000.00	10,120,000.00
Дотоод албан томилолт		17,830,000.00	10,120,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		171,227,398.00	207,565,113.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		171,227,398.00	207,565,113.00
Бараа үйлчилгээний бусад зардал		1,961,965,936.51	1,172,864,344.90
Бараа үйлчилгээний бусад зардал		1,546,195,216.00	173,459,793.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		6,643,190.00	2,506,100.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		409,127,530.51	996,898,451.90
ТАТААС		15,000,000.00	-
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас		15,000,000.00	-
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас		15,000,000.00	-
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		247,024,325.08	462,064,088.22
Бусад урсгал шилжүүлэг		65,856,045.00	13,155,999.00
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		24,705,000.00	7,405,999.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		41,151,045.00	5,750,000.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		181,168,280.08	448,908,089.22
Төвлөрүүлэх шилжүүлэг		181,168,280.08	448,908,089.22
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		89,265,000.00	1,584,491,635.00
Дотоод эх үүсвэрээр		89,265,000.00	1,584,491,635.00
Бусад хөрөнгө		89,265,000.00	1,584,491,635.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3	3,470,967,378.33	4,710,521,151.37
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)		4,361,314,952.60	2,201,521,978.63
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		-	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		-	388,610,416.70
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		-	388,610,416.70
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		-	(388,610,416.70)
НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)		4,361,314,952.60	1,812,911,561.93

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,636,067,875.00	4,551,035,000.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	71,060,050.00	10,653,400.00
Нийтлэг татварын бус орлого	71,060,050.00	10,653,400.00
Төсөв байгууллагын өөрийн орлого	71,060,050.00	10,653,400.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	71,060,050.00	10,653,400.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,565,007,825.00	4,540,381,600.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	2,053,014,025.00	2,362,544,216.00
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,982,669,284.00	2,351,763,789.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,107,589.00	2,166,627.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	60,237,152.00	8,613,800.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,511,993,800.00	2,177,837,384.00

Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,511,993,800.00	2,177,837,384.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,471,142,875.00	2,457,654,923.00
УРСГАЛ ЗАРДАЛ	3,471,142,875.00	2,457,654,923.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,209,118,549.92	1,839,349,464.78
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	670,940,453.69	768,719,383.28
Үндсэн цалин	308,593,151.27	312,427,987.03
Нэмэгдэл	265,157,769.04	325,497,536.00
Унаа хоолны хөнгөлөлт	21,366,457.00	38,336,364.00
Урамшуулал	70,323,474.12	88,365,299.25
Гэрээт ажлын хөлс	5,499,602.26	4,092,197.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	99,183,216.00	95,847,778.75
Тэтгэврийн даатгал	67,287,056.00	63,130,159.75
Тэтгэмжийн даатгал	7,753,192.00	8,177,180.50
ҮОМШӨ-ний даатгал	4,297,915.00	4,088,588.75
Ажилгүйдлийн даатгал	3,966,123.00	4,088,588.75
Эрүүл мэндийн даатгал	15,878,930.00	16,363,261.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	86,858,740.83	92,656,381.75
Гэрэл, цахилгаан	5,523,921.88	10,179,281.75
Түлш, халаалт	81,334,818.95	82,477,100.00
Хангамж, бараа материалын зардал	79,136,703.00	262,992,880.00
Бичиг хэрэг	8,008,550.00	5,499,800.00
Тээвэр, шатахуун	53,450,253.00	52,517,580.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,385,400.00	4,583,800.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,000,000.00	197,822,400.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,292,500.00	2,569,300.00
Норматив зардал	3,500,000.00	877,300.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,500,000.00	877,300.00
Эд хогшил, урсгал засварын зардал	34,742,700.00	49,699,378.00
Урсгал засвар	34,742,700.00	49,699,378.00
Томилолт, зочны зардал	17,830,000.00	10,120,000.00
Дотоод албан томилолт	17,830,000.00	10,120,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	173,625,398.00	187,135,613.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	173,625,398.00	187,135,613.00
Бараа үйлчилгээний бусад зардал	2,043,301,338.40	371,300,750.00
Бараа үйлчилгээний бусад зардал	2,036,658,148.40	368,501,650.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,643,190.00	2,799,100.00
ТАТААС	15,000,000.00	-
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	15,000,000.00	-
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	15,000,000.00	-
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	247,024,325.08	618,305,458.22
Бусад урсгал шилжүүлэг	65,856,045.00	13,155,999.00
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	24,705,000.00	7,405,999.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	41,151,045.00	5,750,000.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	181,168,280.08	605,149,459.22
Төвлөрүүлэх шилжүүлэг	181,168,280.08	605,149,459.22
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	164,925,000.00	2,093,380,077.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	164,925,000.00	2,093,380,077.00
Дотоод эх үүсвэрээр	164,925,000.00	2,093,380,077.00
Бусад хөрөнгө	164,925,000.00	2,093,380,077.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-164,925,000.00	-2,093,380,077.00
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	574,817,234.31	34,287,298.20	11,348,209,758.83	11,957,314,291.34
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	1,812,911,561.93	1,812,911,561.93
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	574,817,234.31	34,287,298.20	13,161,121,320.76	13,770,225,853.27

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,120,072,800.00	1,742,928,747.78	377,144,052.22	82.2
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,110,072,800.00	1,732,275,347.78	377,797,452.22	82.1
Орон нутгийн төсвөөс	2,110,072,800.00	1,732,275,347.78	377,797,452.22	82.1
төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	10,000,000.00	10,653,400.00	(653,400.00)	106.5
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,000,000.00	10,653,400.00	(653,400.00)	106.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,120,072,800.00	1,742,928,747.78	377,144,052.22	82.2
УРСГАЛ ЗАРДАЛ	1,891,572,800.00	1,485,669,247.78	405,903,552.22	78.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,865,874,800.00	1,472,813,248.78	393,061,551.22	78.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	847,169,600.00	695,674,734.28	151,494,865.72	82.1
Үндсэн цалин	341,488,000.00	312,427,987.03	29,060,012.97	91.5
Нэмэгдэл	405,161,600.00	325,497,536.00	79,664,064.00	80.3
Унаа хоолны хөнгөлөлт	51,920,000.00	38,336,364.00	13,583,636.00	73.8
Урамшуулал	27,000,000.00	15,320,650.25	11,679,349.75	56.7
Гэрээт ажлын хөлс	21,600,000.00	4,092,197.00	17,507,803.00	18.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	105,896,200.00	86,751,563.75	19,144,636.25	81.9
Тэтгэврийн даатгал	72,009,500.00	56,961,053.75	15,048,446.25	79.1
Тэтгэмжийн даатгал	8,471,700.00	7,445,403.50	1,026,296.50	87.9
ҮОМШӨ-ний даатгал	4,235,800.00	3,722,700.75	513,099.25	87.9
Ажилгүйдлийн даатгал	4,235,800.00	3,722,700.75	513,099.25	87.9
Эрүүл мэндийн даатгал	16,943,400.00	14,899,705.00	2,043,695.00	87.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	132,680,000.00	92,656,381.75	40,023,618.25	69.8
Гэрэл, цахилгаан	24,000,000.00	10,179,281.75	13,820,718.25	42.4
Түлш, халаалт	94,370,200.00	82,477,100.00	11,893,100.00	87.4
Хангамж, бараа материалын зардал	264,128,800.00	255,055,698.00	9,073,102.00	96.6
Бичиг хэрэг	5,806,400.00	4,414,800.00	1,391,600.00	76.0
Тээвэр, шатахуун	48,000,000.00	45,665,398.00	2,334,602.00	95.1
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,500,000.00	4,583,800.00	2,916,200.00	61.1
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	197,822,400.00	197,822,400.00	-	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,000,000.00	2,569,300.00	2,430,700.00	51.4
Нормативд зардал	3,500,000.00	877,300.00	2,622,700.00	25.1
Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,500,000.00	877,300.00	2,622,700.00	25.1
Эд хогшил, урсгал засварын зардал	49,700,000.00	49,699,378.00	622.00	100.0

Урсгал засвар	49,700,000.00	49,699,378.00	622.00	100.0
Томилолт, зочны зардал	19,060,000.00	9,670,000.00	9,390,000.00	50.7
Дотоод албан томилолт	19,060,000.00	9,670,000.00	9,390,000.00	50.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	160,050,000.00	127,223,173.00	32,826,827.00	79.5
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	160,050,000.00	127,223,173.00	32,826,827.00	79.5
Бараа үйлчилгээний бусад зардал	298,000,000.00	155,205,020.00	142,794,980.00	52.1
Бараа үйлчилгээний бусад зардал	294,000,000.00	153,420,920.00	140,579,080.00	52.2
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,000,000.00	1,784,100.00	2,215,900.00	44.6
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,698,000.00	12,855,999.00	12,842,001.00	50.0
Бусад урсгал шилжүүлэг	25,698,000.00	12,855,999.00	12,842,001.00	50.0
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,698,000.00	7,405,999.00	292,001.00	96.2
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,000,000.00	5,450,000.00	12,550,000.00	30.3
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	278,500,000.00	257,259,500.00	21,240,500.00	92.4
Дотоод эх үүсвэрээр	278,500,000.00	257,259,500.00	21,240,500.00	92.4
Бусад хөрөнгө	278,500,000.00	257,259,500.00	21,240,500.00	92.4
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	2,120,072,800.00	1,742,928,747.78	377,144,052.22	82.2
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Гүйцэтгэл	Зөрүү дүн
ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,362,544,216.00	(2,362,544,216.00)
Нэмэлт санхүүжилтийн орлого	2,362,544,216.00	(2,362,544,216.00)
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,351,763,789.00	(2,351,763,789.00)
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,166,627.00	(2,166,627.00)
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,613,800.00	(8,613,800.00)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,362,544,216.00	(2,362,544,216.00)
УРСГАЛ ЗАРДАЛ	526,423,639.00	(526,423,639.00)
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	366,536,216.00	(366,536,216.00)
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	73,044,649.00	(73,044,649.00)
Урамшуулал	73,044,649.00	(73,044,649.00)
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,096,215.00	(9,096,215.00)
Тэтгэврийн даатгал	6,169,106.00	(6,169,106.00)
Тэтгэмжийн даатгал	731,777.00	(731,777.00)
ҮОМШӨ-ний даатгал	365,888.00	(365,888.00)
Ажилгүйдлийн даатгал	365,888.00	(365,888.00)
Эрүүл мэндийн даатгал	1,463,556.00	(1,463,556.00)
Хангамж, бараа материалын зардал	7,937,182.00	(7,937,182.00)
Бичиг хэрэг	1,085,000.00	(1,085,000.00)
Тээвэр, шатахуун	6,852,182.00	(6,852,182.00)
Томилолт, зочны зардал	450,000.00	(450,000.00)
Дотоод албан томилолт	450,000.00	(450,000.00)
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	59,912,440.00	(59,912,440.00)
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	59,912,440.00	(59,912,440.00)
Бараа үйлчилгээний бусад зардал	216,095,730.00	(216,095,730.00)
Бараа үйлчилгээний бусад зардал	215,080,730.00	(215,080,730.00)
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,015,000.00	(1,015,000.00)
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	159,887,423.00	(159,887,423.00)

Бусад урсгал шилжүүлэг	300,000.00	(300,000.00)
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	(300,000.00)
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох	159,587,423.00	(159,587,423.00)
Төвлөрүүлэх шилжүүлэг	159,587,423.00	(159,587,423.00)
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,836,120,577.00	(1,836,120,577.00)
Дотоод эх үүсвэрээр	1,836,120,577.00	(1,836,120,577.00)
Бусад хөрөнгө	1,836,120,577.00	(1,836,120,577.00)
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	2,362,544,216.00	(2,362,544,216.00)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 35,356.4 мянган төгрөгийн 3 алдаа¹ илэрснээс аудитын явцад 35,356.4 мянган төгрөгийн 3 алдааг залруулсан. Үүнд:

- Тайлант оны түлш халаалтын зардлын тооцооллыг давтан тооцоолол хийж үзэхэд 8,995.2 мянган төгрөгийн өглөг дутуу бүртгэж тайлагнасан,
- Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын дүнг тодруулга тайлангийн уг дүнтэй тулган баталгаажуулахад 26,361.2 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан,
- Санхүүгийн тайланг хүчингүй болсон Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын дагуу бэлтгэж тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх" 20 дугаар зүйлийн 20.2-д "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаа с баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", санхүүгийн тайлангийн толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 561,506.5 мянган төгрөгийн 5 зөрчил² илэрснээс албан үүргээ биелүүлээгүй 1 зөрчилд сахилгын шийтгэл ноогдуулах албан шаардлага, 2,850.0 мянган төгрөгийн 1 зөрчилд алдаа зөрчлийг таслан зогсож, давтан гаргахгүй байх 1 албан шаардлага, 558,656.5 мянган төгрөгийн 3 зөрчилд хууль хэрэгжүүлэн ажиллах 3 зөвлөмж өгч ажилласан.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 25,965.7 мянган төгрөгөөр их тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

3.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогүй.

3.2 Албан шаардлага

Илрүүлэлт: 1 Тайлант хугацаанд 52,517.5 мянган төгрөгийн тээвэр шатахууны зарцуулалтын тайлан гаргасан эсэх нь баримтаар нотлогдохгүй байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13-д "албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эд хариуцагчид сахилгын шийтгэл ноогдуулах албан шаардлага хүргүүлсэн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусгаан илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт: 2 Зүүн бүсийн төрийн албан хаагчдын спорт арга хэмжээг зохин байгуулан уралдаан тэмцээний зардлаас 2,850.0 мянган төгрөгийн медаль худалдан авсан.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.8-д "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Бусад хангамжийн материалын дансанд бүртгэлтэй хөрөнгийг түүвэрлэн шалгахад 62,396.0 мянган төгрөгийн ажлын гүйцэтгэл дууссан "нутгийн удирдлагын ордон барих", "ахмадын өргөө барих ажлын зураг" төсөв бүртгэлтэй байна.

Энэ нь УСНББОУС-1.16 Бараа материал, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2-д "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: УСНББОУС-ыг хэрэгжүүлэн гүйцэтгэл нь дуусан хөрөнгө оруулалтын зураг төсвийг данс хооронд шилжүүлж бүртгэл тооцоог хийж ажиллах.

Илрүүлэлт 2: Оны эхний 1,292.0 мянган төгрөгийн авлага барагдуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өмнөх оны авлагыг барагдуулах талаар ажил зохион байгуулан, цаашид өглөг авлага үүсгэлгүй төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэн ажиллах.

Илрүүлэлт 3: Шилэн дансны мэдээллийг тулган баталгаажуулахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 21 гүйлгээ буюу 494,968.5 мянган төгрөгийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрээр мэдээлнэ" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Тайлант хугацаанд 52,517.5 мянган төгрөгийн тээвэр шатахууны зарцуулалтын тайлан гаргасан эсэх нь баримтаар нотлогдохгүй байна.	1	-								1	-		
Зүүн бүсийн төрийн албан хаагчдын спорт арга хэмжээг зохин байгуулан уралдаан тэмцээний зардлаас 2,850.0 мянган төгрөгийн медаль худалдан авсан.	1	2,850.0			1	2,850.0							
Бусад хангамжийн материалын дансанд бүртгэлтэй хөрөнгийг түүвэрлэн шалгахад 62,396.0 мянган төгрөгийн ажлын гүйцэтгэл дууссан "нутгийн удирдлагын ордон барих", "ахмадын өргөө барих ажлын зураг" төсөв бүртгэлтэй байна.	1	62,396.0						1	62,396.0				
Оны эхний 1,292.0 мянган төгрөгийн авлага барагдуулаагүй байна.	1	1,292.0						1	1,292.0				
Дүн	4	66,538.0			1	2,850.0		2	63,688.0	1	-		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны мэдээллийг тулган баталгаажуулахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 21 гүйлгээ буюу 494,968.5 мянган төгрөгийг мэдээлээгүй байна.	1	494,968.5							1	494,968.5
Дүн	1	494,968.4							1	494,968.4

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн тайланг бэлтгэхдээ хүчингүй болсон Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын дагуу бэлтгэсэн	1	-			1	-	1	-				
Тайлант оны түлш халаалтын зардлын тооцооллыг давтан тооцоолол хийж үзэхэд 8,995.2 мянган төгрөгийн өглөг дутуу бүртгэж тайлагнасан	1	8,995.2			1	8,995.2	1	8,995.2				
Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын дүнг тодруулга тайлангийн уг дүнтэй тулган баталгаажуулахад 26,361.2 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан	1	26,361.2			1	26,361.2	1	26,361.2				
Дүн	3	35,356.4			3	35,356.4	3	35,356.4				